

22
150

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны
2012 он 02 дугаар сарын 15-ны өдрийн
34 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр
“Шарын гол” хувьцаат компани
Хаяг, утас
Дархан-Уул аймаг, Шарын гол сум, өөрийн байр утас: 2235
Хурал хуралдах огноо, цаг, газар
2014.04.30-ны 15:00 цагаас “Корпорейт хотел”ХХК-ийн хурлын танхимд
Хурал хуралдах шийдвэр гарсан огноо
2014.02.18
Олон нийтэд зарлах огноо
2014.02.23
Бүртгэх өдөр
2014.03.05
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер дилерийн компанид хүргүүлэх огноо
2014.03.25
Хүргүүлсэн огноо
2014.02.21
Хурлын баримт, бичгийн хуудсын тоо 2 ширхэг, 10 хуудас

КОМИССЫН ДАРГА  /Б.Батмөнх/
2014 оны 02 дүгээр сарын 21 – ний өдөр



ХҮЛЭЭН АВСАН:
БҮРТГЭЛИЙН МЭРГЭЖИЛТЭН

..... оны дүгээр сарын –ний өдөр

Дээрх мэдээллийг, хавсралт материалын хамт 2 хувь үйлдэж Санхүүгийн зохицуулах хороо. “Монголын хөвөнгийн бирж” ХК-л тvc тvc иvvлнэ.

25
151



БАТЛАВ: ТУЗ-ийн дарга


Б.Батмөнх

Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлаж хуралдуулахад хийгдэх ажил, цаг хугацааны график

Хуулийн эцсийн хугацаа	Төлөвлөж буй хугацаа	Хийгдэх ажил	Бэлдэх материалууд
Санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор 2 сарын 20	2 сарын 18-ны 16 цаг	Ногдол ашиг тараах эсэх шийдвэр гарах /тогтоол гарна/	-Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар ногдол ашиг тараах эсэх талаар шийдвэр гаргаж, ногдол ашгийн хэмжээ, тараах хэлбэр, бүртгэлийн одрийг тогтоох
ТУЗ-ийн шийдвэрийг гарснаас ажлын 3 хоногийн дотор хүргэх	2 сарын 21	Ногдол ашгийн талаарх мэдээлэл хүргэх	-Ногдол ашиг хуваарилах тухай мэдэгдлийг хурлын материал, шийдвэрийн хамт, ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногийн дотор СЗХ, МХБ-д хүргүүлэх
Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу 40-өөс доошгүй хоног 3 сарын 01	2 сарын 18	ХЭХ хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр гарах /тогтоол гарна/	-ТУЗ-ийн хурлаар хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлуудыг баталсан байх 1. Компанийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт 2. Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан 3. ТУЗ-ийн 2014 оны цалин урамшуулал, зардлын төсөв 4. Ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэр 5. Хурал хуралдуулах зар гаргах өдөр, бүртгэлийн өдөр, саналын хуудасны агуулга, загвар 6. Хурлын дарга, хуралд бэлтгэх комисс, тооллогын комисс томилох
ХЭХ хуралдуулах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор мэдээлэл хүргэх 3 сарын 04	2 сарын 21	ХЭХ хуралдуулах тов, хэлэлцэх асуудлын талаарх мэдээллийг СЗХ, МХБ д хүргүүлэх	-Уг шийдвэр бүхий мэдээлэлд: 1. Хурлын мэдэгдэл 2. Хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэр /тогтоол/ 3. Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээллийн жагсаалт, бэлэн болгох эцсийн хугацаа 4. Хэвлэл мэдээлэлийн хэрэгслэлээр шийтгэд мэдээлэх зарын загвар
ХЭХ-ыг хуралдуулах шийдвэр гарснаас хойш 5 хоног 3 сарын 06	2 сарын 23	ХЭХ-ын зар гаргах	-ХЭХ-ын зард зайлшгүй орсон байх мэдээлэл /МХБ-ийн сайт, өдөр тутамын 2-оос доошгүй сонин/ 1. Хурал хуралдуулах газар, өдөр, цаг

27
12

			2. Бүртгэлийн өдөр 3. Хурлын хэлэлцэх асуудлууд гарах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй танилцах журам, газар, ажиллах цаг 4. Хурал хуралдуулах зар гаргах өдөр, журам 5. Хурлын комиссын дарга, гишүүдийн утас, электрон хаяг, ажиллах цагийн хуваарь 6. Шаардлагатай бусад мэдээлэл
3 сарын 16	3 сарын 05	Бүртгэлийн өдөр /ХЭХ-ын зар гарснаас хойш 10 дахь өдөр/	
3 сарын 21	3 сарын 10	Зар давтан гаргах	-ХЭХ-ын зарыг гаргаснаас хойш 15 хоногийн дараа зарыг давтан гаргана
Хэлэлцэх асуудал, гарах шийдвэрийн төсөл холбогдох баримт бичгийг, анх зар гарсан өдрөөс хойш 5 хоногт багтаан, брокерт хүргэнэ. 3 сарын 11	3 сарын 20	ХЭХ-ын баримт бичгийг брокер диллерийн компаниудад гэрээний дагуу хүргүүлэх	-ХЭХ-ын материалыг товхимол болгон ХЭ-дэд урьдчилан таниулах зорилгоор брокер диллерийн компаниудад хүргэж байрлуулна.
3 сарын 01	3 сарын 01-ээс өмнө	Санхүүгийн жилийн эцсийн тайлан, аудиторын дүгнэлтийг хүргүүлэх	-Санхүүгийн жилийн эцсийн тайланг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу гаргаж аудиторын дүгнэлтийн хамт СЗХ, МХБ-д хүргүүлэх, өдөр тутмын сонинд мэдээлэх
ХЭХ хуралдах 4 сарын 30	4 сарын 30	ХЭХ хурал хуралдуулах	-Санхүүгийн жил дууссанаас хойш 4 сард багтаана.
5 сарын 31		ХЭ-ийн ээлжит хурлын материал, гаргасан шийдвэрийн хамт СЗХ, МХБ-д хүргүүлэх	

График хийсэн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга  -Л.Батсуурь



SHARYN GOL JSC

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

**Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай**

Компанийн тухай хуулийн 59.60 дугаар зүйл, компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах журмын 2.3 зүйлийн заалт болон Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын шийвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15:00 цагаас “Корпорейт” зочид буудлын хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

- а. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг батлах
- б. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсвийг батлах
- в. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах, бүртгэлийн өдрийг 2014 оны 3 сарын 05-ны өдөр байхаар тогтоосугай.

4. Хурал хуралдуулах тухай хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэх өдрийг 2014 оны 2 дугаар сарын 23, санал авах хуудас хүлээн авах сүүлчийн хугацааг хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах өдрөөр тус тус тогтоосугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын хувьцаа эзэмшигчдээс санал авах хуудасны загварыг /хавсралт 1/-ээр, хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдож хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтын жагсаалтыг / хавсралт 2/-аар тус тус баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдийн танилцах бичиг баримтыг хуулийн хугацаанд бэлэн болгохыг Гүйцэтгэх захирал /Грам Чапман/, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал /Жимми Уайлд/, Санхүү эрхэлсэн захирал / Жеймс Флорес/ нарт даалгасугай.

26
154

7. Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар ТУЗ-ийн дарга Б.Батмөнхийг томилсугай.

8. Хуралд бэлтгэх, зохион байгуулах комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын дарга: Б.Батмөнх

Гишүүд: Д.Байлхүү – ТУЗ-ийн гишүүн

Жеймс Пассин – ТУЗ-ийн гишүүн

Л.Батсуурь – Нарийн бичгийн дарга

Б.Отгонзул – БХХОХ Захирал

Л.Эрхбаатар – ЗААЭ Дэд Захирал

9. Хурлын тооллогын комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын дарга: Б.Батбаатар – ТУЗ-ийн гишүүн

Гишүүд: Д.Даянбилгүүн – ТУЗ-ийн гишүүн

Л.Оюундарь – Эдийн засагч

10. Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл хангах ажлын төлөвлөгөө гаргаж зохих журмын дагуу хуралдуулахыг комисс /Б.Батмөнх/-д даалгасугай:

ДАРГА



Б.БАТМӨНХ

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны
... дүгээр тогтоолын хавсралт 1

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын
хэлэлцэх асуудлаар хувьцаа эзэмшигчдээс
САНАЛ АВАХ ХУУДАС



Хувьцаа эзэмшигчийн овог нэр
Регистерийн дугаар
ХЭ-ийн бүртгэлийн дугаар
Эзэмшиж буй хувьцааны төрөл
Тоо

Ээлжит хурал 20 ... оны дүгээр сарын-ны өдрийн цагаас д болно.

д/д	Хэлэлцэх асуудлын нэр	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал

Саналын хуудас хүлээн авах эцсийн өдөр дүгээр сарын болно.

Хувьцаа эзэмшигчдийн гарын үсэг

Саналын хуудас хүчинтэйд тооцон тоолсон

Тооллогын комиссын дарга

Гишүүд


Хүчингүйд тооцсон бол шалтгаан

Санал авах хуудсыг ашиглах санамж

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 976-11-311073. 99293913.

28
756

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2014 оны
... дүгээр тогтоолын хавсралт 2



“Шарын гол” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
хуралдах үед хувьцаа эзэмшигчдийн танилцах
баримт бичгийн жагсаалт

1. “Шарын гол” ХК-ийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны тайлан
2. “Шарын гол” ХК-ийн санхүүгийн жилийн тайлан
3. Санхүүгийн жилийн тайлангийн талаарх аудитын байгууллагын дүгнэлт
4. Тайлангийн жилд хийгдсэн сонирхолын зөрчилтэй хэлцэл, түүнийг хууль журмын дагуу хийсэн эсэх тухай аудитын байгууллагын дүгнэлт
5. “Шарын гол” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээд, түүний эзэмшиж буй хувьцааны төрөл, тоо
6. “Шарын гол” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын зардал, цалин урамшуулал

Мөн нийгмийн халам-
авагчдын тэтгэврийн хэмжээ
наад зах нь сард 20,0 мянган
төгрөгөөр нэмэгдсэн гэсэн үг
юм.

Мөн нийгмийн халам-

хэзээ гарсан бэ?

-Засгийн газрын үйл
ажиллагааны хөтөлбөрт тэт-
гэвэр, тэтгэмжийн хэмжээг
нэмэгдүүлэхдээ нийтэд урьд-
чилан зарлахгүй гэсэн

виар нэмэгдүүлээ гэж
яригдаад байна, ямар тэт-
гэвэр ингэж нэмэгдэж бай-
гааг тайлбарлаж өгөхгүй
юу?

-Улсын хэмжээнд 318,0

лийн дагуу 10 жилээ ажил-
ласнаар нөхөн тооцуулсан
гэж үзвэл, тэтгэврийн хэмжээ
нь хамгийн багадаа 15,4
хувиар нэмэгдэж, мөн 2 ду-
гаар сарын 01-нээс хэрэгж-

17
а
х
б
р
4
а:



SHARYN GOL JSC

Санхүүгийн тайлан

Шарын гол ХК

2013 оны IV улирал
/аудитлагдаагүй/

Аж ахуй нэгж, байгууллагын нэр

/төгрөг/

Мөрийн дугаар	БАЛАНСЫН ЗҮЙЛ		12-р сарын 31
А	Б		1
1	ХӨРӨНГӨ	Assets	
1.1	Эргэлтийн хөрөнгө	Current assets	
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	Cash and equivalent	5,310,853,108.36
1.1.2	Бусад эргэлтийн хөрөнгө	Other current assets	12,329,929,040.87
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	Total current assets	17,640,782,149.23
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	Non-current assets	
1.2.1	Үндсэн хөрөнгө	PPE	23,063,892,244.37
1.2.2	Биег бус хөрөнгө	Intangible assets	40,563,721.14
1.2.3	Бусад эргэлтийн бус хөрөнгө	Other non-current assets	18,769,331,792.75
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	Total non-current assets	41,873,787,758.26
	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	TOTAL ASSETS	59,514,569,907.49
2	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмч	Liability & equity	
2.1	ӨР ТӨЛБӨР	Liability	
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	Current liability	
2.1.1.1	Дансны өглөг	AP	8,916,620,471.10
2.1.1.2	Бусад өглөг	Other	867,702,371.94
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	Total current liability	9,784,322,843.04
2.1.1.3	Урт хугацаат өр төлбөр	Non-current liability	11,563,303,760.66
	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН	TOTAL LIABILITY	21,347,626,603.70
2.3	Эзэмшигчдийн өмч	Equity	
2.3.1	Өмч: а) төрийн	State owned equity	
2.3.2	б) хувийн	Private equity	1,023,138,900.00
2.3.3	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Retained earnings	3,818,761,884.98
2.3.4	Бусад	Other	33,325,042,518.81
	Эзэмшигчдийн өмчийн дүн	Total equity	38,166,943,303.79
2.4	Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн	Total Liability & equity	59,514,569,907.49

ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2013 оны IV улирал

/төгрөг/

Д/д	Үзүүдэлт		12-р сарын 31
2.1	Борлуулалтын орлого (нэвэр)	Net sales income	21,805,785,634.88
2.2	Үндсэн үйл ажиллагааны зардал	OPEX	(18,601,981,298.51)
2.3	Үндсэн үйл ажиллагааны (ашиг)	Earnings from main operation	3,203,804,336.37
2.4	Үйлдвэрийн бусын (алдагдал)	Non-industrial loss	(216,640,481.32)
2.5	Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	Non-operation loss	(1,125,553,011.21)
3.0	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	EBT	1,861,610,843.84
3.1	Орлогын татварын зардал	Income tax expense	(703,645,165.50)
4.0	Татварын дараах ашиг (алдагдал)	EAT (earning after tax)	1,157,965,678.34



ХАЙ



ХАЙ



ДУЕ



ЧЭ

700

29
208

**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигч
нэгдмэл сонирхолтой компаниуд**

2013 оны 12-р сарын 31-ний байдлаар

№	Хувьцаа эзэмшигч	Хувьцааны тоо	Хувь	
1	SHG HOLDING 3 S.A.R.L	2.318.451	22.6	
2	SHG HOLDING 2 S.A.R.L	2.028.906	19.8	
3	NIHAN HOLDINGS S.A.R.L	1.598.889	15.6	
4	SHG HOLDING 1 S.A.R.L	1.142.674	11.1	
5	ELISE HOLDING S.A.R.L	124.980	1.2	
6	LEXIK HOLDING S.A.R.L	94.350	0.9	
	Дүн	7.308.250	71.4	



**“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн
анхааралд**

“Шарын гол” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2014 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 15 цагаас “Корпорейт” зочид буудлын хурлын танхимд хуралдана.

Хуралд хэлэлцэх асуудал

1. Компанийн 2013 оны үйлдвэрлэлийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн дүгнэлт бүхий тайланг батлах.
2. Компанийн ТУЗ-ийн гишүүдийн 2014 оны цалин урамшуулал болон зардлын төсөв батлах
3. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр 2014.03.05 байна.

Хурал хурагдах зарыг МХБ-ийн цахим хуудас, сонин, задиогоор 2014.02.23, 2014.03.10-ний өдрүүдэд мэдээлнэ.

Хурлын хэлэлцэх асуудлууд гаргах шийдвэрийн төсөл, түүнтэй холбогдох баримт бичигтэй харьяа брокер дмллериин компаниуд болон компанийн төв оффист ажлын цагаар танилцаж болно.

Хурал зохион байгуулах комисс

Холбоо барих утас: 976-11-311073

99293913

99031917

Электрон шуудан: otgonzul@sharyngol.com



SHARYN GOL JSC

**“ШАРЫН ГОЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2014 оны 02 сарын 18 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Компанийн тухай хуулийн 46.1-р зүйл, компанийн дүрмийн 12-р бүлгийн заалт болон ТУЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Уурхайн уулын ажлын өрнөл, техник тоног төхөөрөмжийн шинэчлэл болон шинээр нээгдэх уурхайн хөрс хуулалтын коэффициент их байгаагаас гарах зардал өндөр, хөрөнгө оруулалтын хэмжээ өсч байгаа зэргээс шалтгаалан 2013 оны жилийн ажлын үр дүнгээр ногдол ашиг хуваарилахгүй байхаар тогтоосугай.

2. Энэхүү тогтоол, түүнтэй холбогдсон шалтгаан, тооцоолол бүхий тайлбарыг хувьцаа эзэмшигчдэд мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг компанийн төлөөлөн удирдах зөвлөл /Б.Батмөнх/-д даалгасугай.

ДАРГА



Б.БАТМӨНХ